

2018 ОНЫ БИЕЙН ТАМИР АЙМГИЙН ЧАНАРТАЙ ТЭМЦЭЭН НААДАМ

Сэлэнгэ аймгийн "Таван хан" бөхийн дэвжээ байгуулагдсанаас хойш жил бүр уламжлал болгон сум бүрт үндэсний бөхийн барилдааныг сурталчилан дэлгэрүүлэх залуу бөхчүүд болон бөхийн арга техник, ёс жаягийг өвлүүлэн, монгол сайхан уламжлалаа хадгалан энэ удаагийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын харьяат Монгол улсын начин Б.Дэмбэрэл агсаны нэрэмжит болгон 10 дахь удаагаа Аймаг цэргийн цолтой бөхчүүд, сумын заан залуу бөхчүүд гэсэн 2 насны ангиллаар барилдааныг Ерөө суманд зохион байгууллаа. Тус барилдаанд нийт 78 бөх оролцож тойргийн журмаар барилдаж цолтой бөхчүүдээс Сэлэнгэ аймгийн Баянгол сумын харьяат Аймгийн арслан Б.Уугандаваа түрүүлсэн бол залуу бөхчүүдээс Жавхлант сумын харьяат залуу бөх Э.Энхтүвшин түрүүлсэн. Энэ удаагийн барилдааныг Ерөө сумын "Батхаан майнинг" ХХК, "Шинэ тайга" ХХК, СББХК ивээн тэтгэж сум орон нутагт үзүүштэй сайхан барилдааныг явууллаа.



Монгол уламжлалт наадгай шагайн харваан Аймгийн нээлттэй тэмцээнд Сүхбаатар, Сайхан, Баруунхараа, Мандал, Зүүнбүрэн Хөтөл зэрэг сум тосгодын 80 гаруй харваачид оролцон



хараа хурц, цэц мэргэнээ сорин тэргүүн байр Жаргал ахлагчтай Мандал сум, дэд байранд Б.Ууганбаатар ахлагчтай Хөтөл, гутгаар байранд Б.Болд ахлагчтай Сүхбаатар сумын баг удааллаа.

Сэлэнгэ аймгийн сайхан суманд Ч.Үнэнмөнхийн нэрэмжит чөлөөт бөхийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг уламжлал ёсоор зохион байгууллаа. Энэ удаагийн тэмцээнд 13 сум, байгууллагын 218 зэрэг цолтой чансаатай тамирчид оролцсон нь барилдааныг улам хурцалсан, арга туршлага, оюун ухаанаа уралдуулсан сайхан барилдааныг сумын нийт иргэдэд үзүүлж чадсан. Тэмцээний үеэр Спортын мастер Ч.Үнэнмөнхийг сүүлийн 5 жил өөрийн зардлаар ивээн тэтгэн явуулж чөлөөт бөхийн спортыг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлэн Монголын чөлөөт бөхийн холбооны дээд шагнал "Ялалт" одонгоор шагналаа.



УИХ-ын гишүүн Н.Оюундарийн нэрэмжит өсвөрийн шатарчдын аймгийн аварга



шалгаруулах тэмцээнд 17

сумын 20 гаруй клубын 400 гаруй шатарчид өрсөлдөж дүнгээ гаргалаа. Багийн дүнгээр 6 алт 3 мөнгө 2 хүрэл медаль авч Бат-очир дасгалжуулагчтай Таван хан клуб тэргүүн байр, 3 алт 2 мөнгөн медаль авч Бяцхан мастер клуб дэд байр, 2 алт 3 мөнгө 1 хүрэл медаль авч Мандал Чесс клуб гутгаар байр эзэллээ. Энэ тэмцээн нь оюуны спортыг орон нутагт хөгжүүлэх өсвөрийн шатарчдын чансааг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн сайхан тэмцээн боллоо.

Цасны баярыг уламжлан зохион байгуулж явуулж хэвшүүлснээр Сайхан, Ерөө, Баруунбүрэн, Цагааннуур, Баянгол, Мандал, Сүхбаатар суманд уламжлан зохион байгуулсан. Энэ удаагийн арга хэмжээнд давхардсан төрлөөр



23 арга хэмжээг зохион байгуулж 54 аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулан нийт 5100 гаруй иргэдийг хамруулсан байна.



Сүхбаатар сумын цас баяр нь "Эрүүл агаар эм" нэртэйгээр уламжлал ёсоор 3 дахь жилдээ НАМЗХолбоо ивээн тэтгэн явуулж 14 байгууллагын 500 гаруй хөдөлмөрчид аж ахуйн нэгж байгууллагуудыг ажилчдыг өргөнөөр татан оролцуулж спорт, нийтийн биеийн тамирын 4 / чарганы буухиа, олс таталт, сумо, хийн буу / төрлөөр арга хэмжээг зохион байгуулан энэ арга хэмжээнд байгууллага хамт олноо идэвхтэй оролцуулан тэргүүн байранд шалгарсан багуудыг шагнаж урамшууллаа.

Тэмцээнийг НАМЗХолбоо ивээн тэтгэж хүмүүсийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх чиглэлээр шинээр хоёр номинаци гарган шилдэг спортлог номинацид н.Энхбат даргатай Цагдаагийн газар, "Шилдэг отог"-оор Х.Дамдинсүрэн захирагчтай ХЦ-ийн 0243-р анги шалгарлаа.





ЕББДунд 6-р сургуулийн нэрэмжит өсвөр, насанд хүрэгчдийн ширээний теннисний аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 6-р сургууль дээр зохион байгуулж сургуулийн



удирдлаг, багш нар үйл ажиллагаанд оролцож байгаа

нь спортыг хөгжүүлэхэд мэдлэг чадвар дадал туршлаг хуримтлуулж байгаа нь үнэлэн тус сургуулийг Аймгийн ширээний теннисний Холбоо, Биеийн тамир спортын



газраас ширээний теннисний спортыг хөгжүүлэхэд гол бааз сургууль болгон материаллаг баазаар хангахаа илэрхийлэн эхний ээлжинд 4 ширээ, теннисний буу, 100 ш бөмбөгөөр хангаж тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүллээ. Өсвөр, насанд хүрэгчдийн ширээний теннисний аймгийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Ширээний теннисний холбоог шинэчлэх хурлыг зохион байгуулан холбооны даргаар УБТЗ-ын Сүхбаатар

өртөөний дарга Довчинбазарыг дэвшүүлэн нарийн бичгийн даргаар ЕББДунд 6-р сургуулийн биеийн тамирын багш, ширээний теннисний дасгалжуулагч Л.Мягмарсүрэнг сонголоо. Тэмцээнд 6 сумын 11 байгууллагаас насанд хүрэгчид 30, өсвөрийн тамирчид 82 оролцон хурд хүч, авьяас чадвараа сорин уралдлаа. Тэмцээний нийлбэр дүнгээр Сайхан сумын анхдагч хар бүргэд клуб тэргүүлэн удаах байранд ЕББДунд 6-р сургууль, Түнхэл тосгоны баг тамирчид шалгарсан байна.

Жү-до бөхийн өсвөр үеийнхний “ Ирээдүйн одод -2018” олон хотын тэмцээнд БНХАУ, ОХУ-ын Эрхүү, ОХУ-ын Буриад улсын Улан-үд, Хиагтын район, 21 аймаг 9 дүүргийн нийт 47 байгууллагын 1000 гаруй тамирчид охид 2 насны ангиллаар 10 жинд, хөвгүүд 3 насны ангиллаар 8 жинд 2 өдөр өрсөлдөж дүнгээ гаргалаа. Жин тус бүрд Охид Г.Саранзаяа дасгалжуулагчтай Женко клуб 4 алт, 2 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж тэргүүн байр, Г.Сарангоо дасгалжуулагчтай Шинэ бадрах дэмжээ 4 алт, 2 мөнгө, 5 хүрэл медаль авч ДЭД байр, М.Очирбат дасгалжуулагчтай Хөвсгөл аймгийн баг 2 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж гутгаар байр, Хөвгүүд 3 алт, 3



мөнгө, 6 хүрэл медаль хүртэж Д.Оюунтөмөр дасгалжуулагчтай СЭЛЭНГЭ аймгийн баг Тэргүүлж, 3 алт, 3 мөнгө, 2 хүрэл медалиар Г.Эрдэнэбат дасгалжуулагчтай Улаанбаатар хотын Спортын сургууль дэд байр, 2 алт, 1 мөнгө, 6 хүрэл медалиар Б.Энхбаатар дасгалжуулагчтай Шинэ бадрах дэвжээ гутгаар байр эзэллээ. Тийн

унжлагат ХҮИ жарны Шороон нохой жилийн сар шинийн баярт зориулсан Үндэсний бөхийн барилдааныг Аймгийн засаг даргын ивээл дор явагдаж ахмад бөхчүүд, сурчид, уяачдыг нийт 12 хүнийг шагнаж урамшуулан хүчит 32 бөх барилдсанаас Улсын харцага Б.Одгэрэл, Улсын начин Ч.Баянмөнх, Улсын начин Б.Дэлгэрсайхан, Аймгийн арслан Б.Уугандаваа нар шөвгөрч Улсын харцага Б.Одгэрэл түрүүлж



Улсын начин Ч.Баянмөнх үзүүлэн Сэлэнгэ түмнийхээ сэтгэл санааг баясгасан сайхан наадмыг зохион байгууллаа.

Монголын багш нарын 49 дахь удаагийн спортын арга хэмжээг 6-н төрлөөр /шатар, даам, шагайн харваа, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, буухай / бүсчилэн зохион байгуулан шигшээ тэмцээнийг Цагааннуур суманд явуулж тус арга хэмжээнд шигшсэн 5 бүсийн сургууль байгууллагын 150 гаруй багш, дасгалжуулагч нар оролцож бэлчир бүсийн багш тэргүүлэн шилжин явах цомоо хадгаллаа.

Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд 12 сумын хөвгүүд 20, охид 21 нийт 41 багийн 370 гаруй тамирчид оролцон өрсөлдөж жил бүр оролцогчдийн тоо нэмэгдэн сум орон нутгийн багуудын тоглох ур чадвар нэмэгдэн хөвгүүдээс 1-р байр Ж.Ууганбаяр дасгалжуулагчтай



Орхон ЕБС, охидоос 1-р байр

А.Амартүвшин

багштай Алтан бөмбөг, багийн дүнгээр тэргүүн байр Алтан бөмбөг Спортын сургууль дэд байр Мандал 3-р сургууль гутгаар байр



Орхонтуул ЕБС эзэлж Цомын эзэд боллоо.

Монгол улсад шинэ үеийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсан 97 жилийн ой, Монгол цэргийн баярыг тохиолдуулан цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд уламжлал явуулдаг кроссын тэмцээнийг "Бид гүйж чадна" нэртэйгээр ЕБСургуулиудын дунд явуулан



тэмцээнд Сүхбаатар сумын 3 сургууль, Алтанбулаг Дулаанхан сумын сургуулийн 2 баг нийт 6 баг оролцож тэргүүн байр Баярчимэг ахлагчтай Алтанбулаг



сумын 1-р баг

Дэд байр А.Энхмэнд ахлагчтай Спортын сургууль
Гутгаар байр М.Халиун ахлагчтай Алтанбулаг сумын 2-р баг тус тус удааллаа.

Монгол улсад шинэ үеийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсан 97 жилийн ой, Монгол цэргийн баярыг тохиолдуулан цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд уламжлал болон явагддаг сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, АКМ болон гар бууны тэмцээн, марш тактикийн тэмцээнүүдийг зохион байгуулж ангийн бие бүрэлдэхүүний ур чадвар мэдлэг сурсан эрдмийг нь харуулж чадсан арга хэмжээ боллоо гэж үзэж байна.

Шинэ үеийн зэвсэгт хүчэн үүсч хөгжсөний 97 жилийн ойн хүрээнд Марш тактик, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, урлаг, ажил мэргэжлийн 11 тэмцээнийг явуулан манай байгууллагаас зохион байгуулсан нийлбэр дүнгээр анги хамт олон, цэргийн бүрэлдэхүүнийг сайн зохион байгуулан ур чадвар, авьяас билгээрээ шалгарч 0243-р анги оны аварга ангиар тодорлоо



Эх орончдын өдрийг тохиолдуулан үндэсний спортын төрөл шагайн харвааг Ерөө, Цагааннуур, Сайхан, Мандал, Сүхбаатар суманд аймгийн шагайн холбоо нь зохион байгуулан нийт давхардсан тоогоор 320 гаруй харваачид оролцсон таван бүсийг хамруулсан томоохон арга хэмжээг зохион байгуулж Ерөө, Сайхан Орхон суманд ахмад тамирчдын алдрыг мөнхжүүлэх чиглэлээр нэрэмжит тэмцээнүүдийг зохион явуулсан нь харваачдын ур чадварыг нэмэгдүүлэх нааштай үйл ажиллагааг бодлого баримтлан явууллаа.

Аймгийн засаг даргын нэрэмжит Цомын төлөөх нөхөрсөг тэмцээн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг нийт 51 байгууллагыг хамруулан зохион байгуулах газраас хуваарилсаны дагуу 25 багийн 500 гаруй албан хаагчид спортын 5 төрөлд 3 өдөр өрсөлдөж төрийн байгууллагын ажилчдын эрүүл мэндийг хамгаалсан хөдөлгөөний дутагдлыг арилгаж чадсан бөгөөд жил бүр хүсэн хүлээж түүнд оролцоход хамт олноо бэлтгэсэн үр дүнтэй арга хэмжээний нэг юм.



Тэргүүн байр 37 оноогоор Сүхбаатар зангилаа тэргүүлж Цомын эзэн,
Дэд байр 60 оноогоор ЭМГ, Нэгдсэн эмнэлэг

Гутгаар байр 69 оноогоор Гаалийн газар эзэлж өргөмжлөл мөнгөн шагнал хүртлээ.

Сэлэнгэ



аймгийн Биеийн
тамир спортын
газрын харъяа Усан
спорт сургалтын
төвөөс зохион
байгуулсан “Би сэлж
сурсан” анхдугаар

тэмцээнийг амжилттай зохион байгууллаа . Тус



тэмцээнд 9-11 ,12-14,15-17 насны ангилалд Мэлхий сэлэлт 50м,100м, Өврөөр даллах сэлэлт 100м, 150м гэсэн төрлүүдээр явагдлаа. Тэмцээнд 30 гаруй эрэгтэй эмэгтэй тамирчид оролцлоо. Аймгийнхаа усан спортын тамирчдын ур чадвар бэлтгэл сургалтыг сайжруулах зорилт чиглэлээр бодлого дэвшүүлэн Усан спортын төвтэй хамтран ажиллаж хамтарсан сургалтыг 2 удаа зохион байгуулан явуулсан нь тамирчдад маш их үр дүнгээ өгч анхны Улсын аварга шалгаруулах тэмцээнд 6 тамирчин амжилттай оролцоод ирсэн.

Баянгол сумыг 12 жилийн сургууль нь сургуулиараа даамчин болох зорилтыг дэвшүүлэн даамны аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнийг ЗДТГазартай хамтран хүлээн авч зохион байгуулан 8 хүртэл, 8-10, 11-12, 13-14, 15-16 насны ангиллаар явагдан тэмцээнд Сүхбаатар, Мандал Баянгол, Сайхан, Цагааннуур сумаас нийт 130 гаруй тамирчид оюун ухаанаа дайчлан багийн дүнгээр Баянгол сумын баг тамирчид тэргүүлсэн амжилтыг үзүүлсэн байна. Мөн насанд хүрэгчдийн дунд Улсын хэмжээнд нээлттэй тэмцээнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган аймаг орон нутгаас орох багийн бүрэлдэхүүнээ сонгон шалгаруулан хүчтэй баг оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Есүүхэй-цом 2018 оны Өсвөр үеийнхний сагсан бөмбөгийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ аймгийн цагдаагийн газрын дарга асан цагдаагийн хурандаа Г.Эрдэнэбат 2 дахь жилдээ амжилттай явуулан тус тэмцээнд 8 сум 1 тосгоны охид 15 хөвгүүд 20 нийт 36 багийн 320 гаруй тамирчид оролцлоо.



Энэ удаагийн тэмцээнд Сэлэнгэ аймгаас улсад шалгаран U-13,U-14,U-16 насны ангиллалд ХБНГУ, Австри улсад болсон Олон улсын тэмцээн, Малайз улсад болсон Олон улсын хүүхдийн наадмуудад амжилттай оролцож алт мөнгө хүрэл медалиуд хүртсэн шилдэг тамирчид оролцсон нь уг тэмцээний онцлог байлаа. Тэмцээний хөвгүүдээс 1-р байр

Баянгол ЕБСургууль, 2-р байр Мандал 1, 3-р байр Цагааннуур, охидоос 1-р байр Мандал 1, 2-р байр Цагааннуур, 3-р байр Хөтөл ЕБС тус тус эзэлж Багийн дүнгээр 1-р байр Ё.Даваадулам багштай Мандал 1-р сургууль, 2-р байр Б.Энхбаатар багштай Цагааннуур ЕБС, 3-р байр Д.Батбаатар багштай Баянгол ЕБСургуулийн баг тамирчид эзэлж байгаа сум орон нутгийн багш дасгалжуулагч нар сайн ажиллаж байгаа нь харагдаж байна.

Алтан гадас одонт,Ардын боловсролын тэргүүний ажилтан, биеийн тамирын спортын тэргүүний ажилтан аймгийн хурц арслан Ж.Жаргалтулга агсаны нэрэмжит өсвөр үеийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 7 дахь жилдээ Мандал сумын Хэрх тосгонд зохион байгуулан тэмцээнд 17 багийн 87 тамирчин 3 насны ангиллаар хурд хүч авхаалж самбаагаа сорин багийн дүнгээр Цагааннуур сум тэргүүн байранд шалгаран удаах байранд Зүүнбүрэн, Баянгол сумын багууд шалгарсан амжилтуудыг үзүүлсэн.



Хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Төв цэнгэлдэх хүрээлэнд 5 сум 2 тосгон 10 сургуулийн 130-д тамирчид 2 насны ангиллаар 18 зай, төрөлд 84 багц медалийн төлөө өрсөлдөж хурд хүч авхаалж самбаагаа сорисоноос багийн дүнгээр Эрдэнэбаатар багштай Баянгол сургууль тэргүүн байр, Мөнхбаатар дасгалжуулагчтай Алтанбулаг, Бямбадорж дасгалжуулагчтай спорт сургууль тус тус



удааллаа. Төрөл тус бүрт Баянгол сумын сургууль 8 алт, 10 мөнгө, 10 хүрэл, Алтанбулаг 6 алт, 6 мөнгө, 3 хүрэл, Спорт сургууль 6, алт, 3 хүрэл, Хэрх 1 алт, 4 мөнгө, 3 хүрэл, 5-р сургууль 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл, Дулаанхаан тосгоны сургууль 2 мөнгө, 3 хүрэл, Шаамар 1 мөнгөн медаль тус тус хүртлээ.

Ахмад волейболчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ



аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгонд БТСТА волейболын спортын ахмад тамирчин Б.Нарантуяагийн нэрэмжит болгон сумын сургуулийн зааланд хүлээн авч ивээн тэтгэгч



байгууллагатай ярилцан зохион байгуулалтын өндөр хэмжээнд явууллаа. Тэмцээнд Сайхан, Орхон, Орхонтуул, Сүхбаатар, Мандал, Баянгол, Хэрх Рашаант зэрэг эмэгтэй 9 баг эрэгтэй 8 багийн 134 тамирчид оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж эмэгтэй багуудаас тэргүүн байранд Орхонтуул, эрэгтэй Мандал сумын баг тэргүүлэн, удаах байранд Сүхбаатар, Орхон сум баг тамирчид шалгарсан бол, эрэгтэй багуудаас удаах байранд Хэрх, Орхон сумын баг тамирчид шалгарсан байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн 53 тоот зарлигийн дагуу “Биеийн тамир, спортын хамтлагийн арга зүйчдийн дунд туршлага судлах, хамтын ажиллагааны чиг хандлага, цаашдын бодлого тодорхойлох, эргэх уялдаа холбоог сайжруулах нь” чиглэлээр БСШУСЯам, ЗГХАБТСГазраас зохион байгуулсан сургалт чиглэлийн үр дүнг тодорхойлоход орон даяар Бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилын аяныг зарлан Аймгийн хэмжээнд бие бялдрын түвшин тогтоох сорил судалгааг явуулах график төлөвлөгөө гарган бүх сургуулиудад сургалтын материал, албан тоот хүргүүлэн зарим сумдад очиж зааварчилгаа өгч, Сүхбаатар суманд 8 байгууллагыг сонгон хуваарь гаргаж арга зүйч нар өөрсдөө очиж ажиллан судалгааг авч ажиллаа. Монгол улсын ерөнхийлөгчийн 53 тоот албан даалгаврын хэрэгжилтийн дагуу байгууллагууд дээр очиж сорил авах программыг зааж сурган бие бялдрын түвшин тогтоох сорилд 2018 онд Аймгийн хүн амын 0,03 хувь буюу **4800** орчим хүний судалгааг авч ажиллаа..

БТТА,АБТА,БХЯТАжилтан хөдөлмөрийн хүндэт медаль, алтан гадас одонт, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, ахмад багш Ц.Төмөрхуягийн нэрэмжит Биеийн тамирын багш нарын олимпиад,сургалтыг БСГазар, 3-рсургуультай хамтран



15 дахь жилдээ зохион байгуулж нийт 12 багш нар оролцож ,олимпиадад 14-15, 16-17 насны ангилалд нийт 54 тамирчид оролцож багш нарынхаа заасан сургасан эрдмийг



харуулан ББялдрын 5 чанараар өрсөлдлөө .Багш нарын бие бялдар ,онолын шалгалтаар Сүхбаатар сумын ЕББ 5-р дунд сургуулийн багш Батхуяг шалгарсан бол тамирчдаас багийн нийлбэр дүнгээр Баянгол сумын бүрэн дунд сургууль эхний байранд шалгарсан байна. Энэ нь багш нарын бүтэн жилийн хийсэн ажлыг дүгнэж цаашид хийж бүтээх урам зориг өгсөн үр нөлөөтэй ажил гэж үзэж байна.



Сэлэнгэ аймгийн Монголын ардчилсан залуучуудын холбооны санаачлагаар аймгийн сагсан бөмбөгийн холбоотой хамтран насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг анхан шатанд бүс хооронд зохион байгуулан шигшээ тэмцээнийг чанаржуулан 20 багийн тоглолтыг Спортын ордонд явуулж хүүхэд залуучуудад үзүүштэй сайхан тоглолтууныг үзүүлэн бие биендээ туршлагаа хуваалцсан тэмцээн болсон. Тэмцээний дүнгээр эрэгтэй багуудаас Баянгол сум, эмэгтэй багуудаас Спорт сургуулийн багууд тэргүүлэн цомын эзнээр тодорсон амжилтуудыг үзүүлсэн байна.

Сүхбаатар сумын 5-р сургуулийн нэрэмжит “Аваргын гараа” өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаан энэ жил уламжлал болон 10 дахь жилдээ зохион байгууллаа. Тэмцээнд 4 насны ангиллаар 180 гаруй тамирчин оролцож байгаа өмнөх онуудынхаас оролцоо өрсөлдөөн нэмэгдэж байгааг харуулсан арга хэмжээ боллоо. Тэмцээний гол зорилго ирээдүйн их аваргыг өвлөн монгол уламжлалт ёс заншлыг



хойч үедээ хадгалуулан үлдээх чиглэлээр хамтран ажиллаж байна. Тэмцээний нийлбэр дүнгээр Мандал сумын баг тамирчид тэргүүлсэн байна.

Аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээн амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 27 багийн 200 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Тэмцээнийг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн аймгийн засаг дарга Ш.Оргил болон биеийн тамир спортын газрын дарга Б.Баттулга нарт нийт харваачид баярласнаа илэрхийллээ, Аймгийн шагайн харвааны холбоо 2018



оны аймгийн аварга шалгаруулах тэмцээний өсвөр насны ангилалд 1-р байранд Ерөө сумын, 2-р байранд Түшиг сумын, 3-р байранд Сүхбаатар сумын 5-р сургуулийн сурагчдын багууд, ахмадын харваанд 1-р байранд Д.Ганбат ахлагчтай Орхонтуул сумын, 2-р байранд Х.Баяраа ахлагчтай Сүхбаатар сумын, 3-р байранд Г.Төмөрбаатар ахлагчтай Алтанбулаг сумын



харваачид, насанд хүрэгчдийн ангилалд 1-р байранд Г.Жаргал ахлагчтай Мандал сумын, 2-р байранд Э.Содэрдэнэ ахлагчтай спорт сургуулийн, 3-р байранд Т.Гантулга ахлагчтай Сүхбаатар сумын харваачид, цуваа харваанд Болор, Т.Амарболд, Т.Гантулга нар тус тус шалгарлаа. Мөн БСШУСпортын сайдын дэвшүүлсэн санал санаачлагаар аймаг орон нутагтаа эмэгтэй харваачдыг бэлтгэх чиглэлийн дагуу бодлог баримтлан харваачдыг татан оролцуулах тэдний ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн эмэгтэй тамирчид оролцсон нь энэ жилийн тэмцээний онцлог байлаа

Сайхан суманд Аймгийн аварга шалгаруулах бага дунд насны өсвөрийн хөл бөмбөгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан тэмцээнийг Сайхан сумын ЗДТГазар, Аймгийн хөл бөмбөгийн холбоотой хамтран явуулж тэмцээнд Сүхбаатар, Мандал, Сайхан, Номгон сумын 12 багийн 154 тамирчин оролцож ур чадвараа гарган түрүүлсэн багууд Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор эрхээ авсан.

Монголын нийтийн бүжгийн спортын холбооны дэргэдэх Сэлэнгэ аймгийн нийтийн бүжгийн Салбар зөвлөлөөс Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг анх удаа амжилттай зохион байгуулж явууллаа. Тэмцээнд 5 хамтлаг, 6 хос оролцов. УБхотоос Н.Дэлгэрмаа багштай ДЭМА ДЭНС, Д.Сувдаа багштай Соёмбо, Дархан хотын Мөнгөнсор хамтлагууд хүндэтгэл үзүүлэн ирж тоглолт хийв. Тэмцээнийг бүжгийн спортын холбооны шүүгч багш Н.Дэлгэрмаа, Д.Сувдаа, Э.Ганзориг нар шүүлээ. Тэмцээний алт мөнгө хүрэл медалийн эздээр Сүхбаатар сумын Сондор хамтлаг, Сүхбаатар сумын Мөнгөн долгио хамтлаг, Ерөө сумын Болор Шигтгээ хамтлаг тодорлоо. Сүхбаатар сумын Жавхаа хамтлаг, 4-р байр, Ерөө сумын Ахмадын золбоо хамтлаг 5-р байранд тус тус орлоо. Хосын тэмцээнд алт мөнгө хүрэл медалийн эзэд тодорсонгүй. Тусгай байранд Баттүвшин, Энхдаваа Нямбаяр, Мөнхцацрал нар шалгарч бүжгийн спортыг сэлэнгэчүүддээ сурталчилаа.



Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Аймгийн Засаг даргын ивээл дор үндэсний сурын харвааг аймаг орон нутагтаа



хөгжүүлэх, уралдаан тэмцээнийг тоог нэмэгдүүлж тамирчдын ур чадварыг дээшлүүлэхэд, сурын монгол сайхан уламжлалыг хадгалан хойч үедээ өвлүүлэн

үлдээх зорилтын хүрээнд халх, буриад, урианхай сурын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнийг цуваа, багийн Орхонтуул сум, ахмадын гэсэн 3 ангиллаар явуулж цуваа харваанд Ц.Ганхүү /Орхонтуул/ багийн хаваанд Орхонтуул сум ахмадын С.Цэдэн-иш /Хушаат/ харваанд нар тэргүүлсэн байна.

Үндэсний халх сурын харваан тэмцээнд 30 гаруй харваачид оролцон Монгол



улсын дархан мэргэн харваач 1, Монгол улсын мэргэн 1, спортын мастер 3, спортын дэд мастер 2 аймгийн цолтой 10 гаруй харваачид оролцсон тэмцээнийг өндөр чансаатай

болгож өгсөн. Эрэгтэй тамирчдаас тэргүүн байранд спортын мастер Б.Отгонболд тэргүүлсэн бол эмэгтэй тамирчдаас Монгол улсын дархан мэргэн харваач С.Энхтунгалаг тэргүүлсэн байна.

Сүхбаатар сумын төвийн цэцэрлэгүүдийн дунд хүүхдийг зам тээврийн хэрэг,



осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийт, хүүхэд багачуудад зам тээврийн осол, хэргийн хор уршгийг таниулах, замын хөдөлгөөнд оролцох дадлыг зөв хэвшүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын



үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг Биеийн тамир спортын газарт зохион байгуулан ажиллаа.

Тус арга хэмжээний үед сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг замын хөдөлгөөний дүрмийн зөв дадлыг эзэмшүүлэх чиглэлээр 7 цэцэрлэг хамрагдаж “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнд оролцсон хүүхэд бүрт гарын бэлэг гардуулав. Тус тэмцээний 1 дүгээр байрыг 3 дугаар цэцэрлэг, 2 дугаар байрыг 4 дүгээр цэцэрлэг, 3 дугаар байрыг 2 дугаар цэцэрлэг тус тус эзэлсэн тул алт, мөнгө, хүрэл медаль гарын бэлгээр шагнав. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зөвлөлөөс 768 мянган төгрөгний санхүүжилтийг гаргасан. Хүүхэд бүрт гарын бэлгийг “Хүүхэд гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-аас гаргуулан ажилласан.

Ардын хувьсгалын 97 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн их баяр наадмаар хүчит 128 бөх барилдаж, үндэсний сурын харваанд 112 тамирчин оролцон, хурдан морины 6 насны уралдаанд 1450 гаруй шандаст хүлгүүд уралдаж баяр наадмыг өргөжүүлэх мөн үндэсний спортын их наадамд тамирчин шалгаруулж оролцуулах чиглэлээр



спорт болон монгол наадгайн төрлөөр 2 насны ангиллаар наадамчин олны дунд / шагай шүүрэх, шагай няслах, гудамжны сагсан бөмбөг, шатар зэрэг спортоор арга хэмжээг зохион байгуулан нийт 230 гаруй спорт сонирхогчдыг татан оролцуулсан.



Улсын их хурлын гишүүн Н.Оюундарийн санаачлагаар Биеийн тамир спортыг иргэн, айл өрх бүрт хүргэх зорилт чиглэлийн дагуу "Иргэдийн спортын анхдугаар наадам"-ыг 5 сум 1 тосгоныг хамруулан спортын 6 төрлөөр явуулж 581 иргэд тамирчдыг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулан явууллаа. Цаашид энэ арга хэмжээг жил бүр уламжлан явуулж байхаар шийдвэрлэсэн.

Аймгийн засаг дарга Ш.Оргилын санаачлагаар түүхийн дурсгалт газрыг сурталчилах, сэргээх, өв уламжлан хамгаалах чиглэлээр зорилгыг эрхэмлэн аймгийн шагайн холбооны үйл ажиллагаа шагайчдын ур чадварыг нэмэгдүүлэхээр түүхийн дурсгалт газар "Буйр хээрийн тойром" -ыг бий болгон шагайн нээлттэй тэмцээнийг жил бүр уламжлан МАНам ивээн тэтгэж явуулж байхаар шийдвэрлэсэн.

Энэ жилийн шагайн тойрмын зохион байгуулалтын ажлыг Аймгийн БТСГазар, Сүхбаатар сумын ЗДТГазар, аймгийн шагайн холбоо хамтран түүхийн дурсгалт газар оргидог булаг дээр зохион байгуулан явуулж тэмцээнд Дархан, Төв, Дорноговь, Булган, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн 9 сум 1 тосгоны нийт 28 багийн 225 туршлагтай өндөр цол зэрэгтэй дархан мэргэчүүд, харваачид оролцсон тойромыг явуулан багийн харваанд Булган аймгийн Үлэмж дархан мэргэн Ч.Түвшинжаргал ахлагчтай баг тэргүүлсэн бол удаах байранд дархан мэргэн Б.Батбаатар, Ж.Гансуурь ахлагчтай Сэлэнгэ аймгийн Хөтөл, Орхонтуул сумын баг тамирчид шалгарсан. Хүн нэг бүрийн цуваа харваанд нийт 114 тамирчид цэц мэргэнээ сорин уралдаж Сэлэнгэ аймгийн Мандал сумын залуу харваач А.Итгэл түрүүлэн,

Улаанбаатар хотын харваач С.Жаалай, Дорноговь аймгийн харваач А.Доржсүрэн удаалсан байна.

Монгол улсын ерөнхий сайдын нэрэмжит БСШУСЯам, ЗГХАБТСГазраас зохион байгуулсан иргэдийн спортын наадам буюу багийн спортыг дэмжих чиглэлээр орон даяар нэгэн зэрэг зохион байгуулсан арга хэмжээг аймаг, орон нутагтаа зохиох дүрэм журмын дагуу анхан шатны /8 сум хамрагдсан/ болон аймаг орон нутгийн хэмжээнд /6 сум / зохион байгуулан спортын 5 / хөл бөмбөг, сагс, волейбол, олс, явган аялал/ төрлөөр явуулж нийт 2358 хүнийг / эмэгтэй 613/ хамруулсан томоохон арга хэмжээг зохион байгуулж багийн нэгдсэн дүнгээр Сүхбаатарын сумын баг тамирчид тэргүүлэн олон хүнийг хамрсан арга хэмжээ боллоо



Улсын их хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын санаачлагаар Сэлэнгэ түмэн буюу Сэлэнгэ лиг арга хэмжээнд спортын 3 төрөл / сагс, волейбол, шатар/ аймгийнхаа 17 сум 6 тосгоныг хамруулан 112 багийн 1300 тамирчдыг оролцуулсан. Энэ тэмцээний онцлог нь Улаанбаатар хотод Сэлэнгэ нутгаа сурталчилан жил бүр уламжлал болон явагдаж байдгаараа онцлог юм. Тэмцээнд Мандал сум тэргүүлэн цомын эзнээр тодорсон.

Ахмадын баярын өдрийг угтан Аймгийн засаг даргын ивээл дор Сэлэнгэ аймгийн ахмадуудын дунд "Бид дуулах дуртай" өдөрлөг буюу 10 бүжгийн аварга шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж ахмадууд өргөнөөр хамрагдан тэдний эрүүл мэндийг хамгаалах хөдөлгөөний хомсдолоос гаргахад чиглэгдсэн томоохон арга хэмжээ боллоо.

Аймгийн засаг даргын нэрэмжит цомын төлөөх тэмцээнийг спортын 5 төрлөөр 17 сум 6 тосгоныг хамруулан бүх төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулсан арга хэмжээг Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 750 гаруй / эмэгтэй 350/ тамирчин төлөөлөгчид оролцуулан биеийн тамир спортод төрийн манлайлалыг харуулан үзэл суртал, зохион байгуулалтын өндөр хэмжээнд бусдад үлгэр дууриал үзүүлсэн арга хэмжээ боллоо. Тэмцээний нэгдсэн дүнгээр зохион байгуулалт спортын ур чадвараа гарган Сүхбаатар сумын төрийн албан хаагчдын тамирчид тэргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрхийг хамгаалах олон улсын өдөрт зориулан Аймгийн засаг даргын тамгын газар, Хүүхэд залуучууд гэр бүл хөгжлийн газар, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран Сэлэнгэ аймагт ажиллаж, аж төрөн амьдарч байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд суугаа волейбол, динго, нисдэг таваг, буухий, урлаг уран сайхны үзүүлбэр гэсэн төрлөөр арга хэмжээг зохион байгуулан нийт 9 сумын 67 тамирчид оролцож хурд хүч оюун ухаан авхаалж самбаагаа сорин уралдаж спортоороо Сүхбаатар сумын 1-р баг тэргүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие бялдарыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдлыг арилгаж тэдэнд урам зориг нэмэгдүүлсэн сайхан арга хэмжээг явуулсан.

Мандал суманд өсвөрийн бөхчүүдэд багаас нь монгол бөхийн арга техник, өв уламжлал ёс жаягийг зааж сургах ирээдүйн олон аваргуудыг бэлтгэх чиглэлээр "Хүүрнэн шуугигч" барилдааныг өөрийн орон нутагт хүлээн авч МҮОНРТ-тэй хамтран монгол орны өнцөг булан бүрээс цугларсан 80 гаруй 5-7 насны бөхчүүд оролцсон барилдааныг зохион байгуулсан

Аймгийн засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Өег гурил ХХК хамтран сэлэнгэ аймагт арвин их ургац хураан авч дуусаны баярт өдрийг тэмдэглэн "Ургацын баяр" -ын үндэсний бөхийн тэмцээнийг зохион байгуулан сум аймаг, улс, цэргийн цолтой хүчит 48 бөхчүүд уран мэхээ уралдуулан барилдаж улсын харцага Батэлзий түрүүлсэн.

2019 ОНЫ БИЕЙН ТАМИР АЙМГИЙН ЧАНАРТАЙ ТЭМЦЭЭН НААДАМ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийн 2019 оны үндсэн чиглэлд тусгасны дагуу Монголын хүүхдийн спортын наадамтай уялдуулан хүүхэд багачуудыг спортоор хичээллүүлэх, оролцогчдын тоог нэмэгдүүлэхээр спортын 8 / чөлөөт бөх, жудо, ширээний теннис, уран хөдөлгөөнт гимнастик, сагсан бөмбөг, волейбол, үндэсний бөх, монгол наадгай / төрлөөр аймгийн нийт 32 ЕБСургуулиудын "Сэлэнгэ бага-олимп" спортын олон төрөлт арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Гэвч Улсын хэмжээнд оны эхэнд хорио цээр тогтоон хөл хорьж хугацаа алдсан боловч өөрсдийн хүч нөөц боллоцоогоо гарган шийдвэрлэж төрлүүдээ явуулж сонгон шалгаруулалтаа хийж чадсан.

"Сэлэнгэ бага-олимп"-ийн анхны тэмцээн чөлөөт бөхийн тэмцээнийг зохион байгуулан тэмцээнд 15 байгууллагын 315 тамирчин оролцож хурд хүч авьяас чадвараа дайчлан барилдаж тэмцээний нийлбэр дүнгээр Амархүү дасгалжуулагчтай БТСГазрын баг тамирчид тэргүүлсэн. Тэмцээний гол ач холбогдол нь "Сэлэнгэ бага-олимп"-ийн хүрээнд явагдсанаар оролцогчдын тоо нэмэгдэн барилдааны чансаа нэмэгдсэн.

Жудо бөхийн тэмцээнийг Баянгол сумын Биеийн тамирын багш Батболдын нэрэмжит болгон Баянгол суманд Аймгийн БТСГазар, Жудо бөхийн холбоо, сумын ЗДТГазар хамтран зохион байгуулан явуулсан. Тэмцээнд 11 сум 3 тосгоны 24 байгууллагын 321 тамирчин оролцож хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж багийн дүнгээр Баянгол сумын баг тамирчид тэргүүн байранд шалгаран бусдыгаа манлайлан оролцсон байна.

Аймгийн аварга шалгаруулах өсвөрийн волейболчдийн тэмцээнийг аймгийн Волейболын холбоо, ЕББДунд 3-р сургуультай хамтран зохион байгуулж тус тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаанд: Сэлэнгэ аймгийн Волейболын Холбооны Тэргүүн УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат, Сэлэнгэ аймгийн засаг дарга Ш.Оргил, Аймгийн засаг даргын нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Б.Нарантуяа, Монгол ардын намын хорооны дарга Рэгзэдмаа, Сүхбаатар сумын Засаг дарга Т.Гантулга нар оролцож баг тамирчдад шагнал гардуулж хүндэтгэл үзүүллээ.

Энэ удаагийн тэмцээнд 12 сумын 37 байгууллагын 437 тамирчин оролцож тэмцээнд ач холбогдол үзүүлэн “Сэлэнгэ бага-олимп”-ийн нээлтийн үйл



ажиллагааг зохион байгууллаа. Тэмцээний нийлбэр дүнгээр Багийн нийлбэр дүнгээр 1-байр Спорт Сургууль 2-р байр Мандал 3-р сургууль 3-р байр СБ 6-р сургууль тус тус шалгарлаа.

Аймгийн аварга шалгаруулах өсвөрийн ширээний теннисний тэмцээнийг аймгийн ширээний теннисний холбоо, ерөнхий боловсролын 6-р сургуультай хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 11 байгууллагын 93 тамирчин 4 насны ангиллаар ганцаарчилсан, холимог хосын төрлөөр хурд, ур чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж байгууллагын нэгдсэн дүнгээр тэргүүн байранд Сайхан сумын Анхдагч хар бүргэд” клубын тамирчид тэргүүлэн удаах байранд Сүхбаатар сумын 6-р сургууль, түнхэл тосгоны сургуулиудын баг тамирчид эзэлсэн байна.



Аймгийн ширээний теннисний холбоотой хамтран насанд хүрэгчид ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 3 дахь жилдээ зохион байгуулж энэ удаагийн тэмцээнд тамирчдын



оролцоог нэмэгдүүлэн Буриад улсаас тамирчдыг урилгаар оролцуулан нийтдээ 60-иад тамирчин оролцож авьяас, ур чадвараа дайчлан өрсөлдсөн тэмцээнд тэргүүлсэн тамирчид насанд хүрэгчид, ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа



Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргилын нэрэмжит өсвөрийн шатарчдын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 6-18 насны ангилалд Мандал, Хөтөл, Шаамар, Алтанбулаг, Орхонтуул Сүхбаатар сумын нийт 330 гаруй өсвөрийн тамирчид оролцож байна. Тус тэмцээнд Ази тивийн аваргын 3 мөнгө 4 хүрэл медальт, Олон улсын дэд мастер, 2019 оны Улсын аварга шалгаруулах тэмцээний

тэргүүн байрт Номиндалай, 2014 оны Улсын аваргын 2 мөнгө, 6 хүрэл медальт, Олон улсын дэд мастер Амин-Эрдэнэ, 2017 оны Ази болон Дэлхий аварга шатарчин Цэлмүүн нар оролцож байна.



Аймгийн Биеийн тамир спортын газрын ажилчдын эрүүл мэнд болон үйл ажиллагааны чиглэлээр зайлшгүй сэлж сурах ба болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах арга



барилгыг эзэмшүүлэх чиглэлээр албан хаагчдын дунд усан сэлэлтийн аварга шалгаруулах 2 дахь удаагийн тэмцээнийг зохион байгууллаа.

Хүүхэд багачуудыг хөдөлгөөний дутагдлаас гарган бие бялдарыг хөгжүүлэх, багийн спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг аймгийн Засаг даргын тамгын газар, Сагсан бөмбөгийн холбоо, БТСГ-тай хамтран зохион байгуулж байна. Тэмцээнд 16 сумын нийт 500 гаруй хүүхдүүд оролцлоо. Энэ удаагийн тэмцээний онцлог Монголын хүүхдийн



спортын 6 дугаар их наадмын өмнө тус наадамд аймгаа төлөөлөн оролцох шигшээ багийг бүрдүүлэхэд оршиж байна. Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Энхбат албан ёсоор нээлээ. Нээлтийн ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын



Санхүү төрийн сангийн дарга, аймгийн Сагсан бөмбөгийн холбооны нарийн бичгийн дарга О.Мөнхбаяр, аймгийн БТСГ-ын дарга У.Батмөнх нарын албаны хүмүүс, баг тамирчид, багш дасгалжуулагчид оролцлоо. **Багийн дүнгээр** Тэргүүн байр: Мандал Дэд байр: Баянгол Гутгаар байр: Сайхан сумын баг тамирчид удааллаа.

Аймаг орон нутагтаа спортын холбоо клубүүдийг дэмжин 2019 онд шинээр сумо бөхийн холбоог байгуулагдан холбооны тэргүүнээр С.Баасанхүү, ерөнхий нарийн бичгийн даргаар улсын начин Б.Дэлгэрсайхан нар сонгогдон хүүхэд залуучуудын дунд сумо бөхийн спортыг дэлгэрүүлэн гол зорилго нь олон аварга



тамирчдыг төрүүлэн сумогийн аварга тамирчинтай болох зорилтыг дэвшүүлэн хүүхэд залуучуудын дунд анхны Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Монголын сумо бөхийн



холбоо, Аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Тус тэмцээний нээлтийн ажиллагаанд Аймгийн засаг дарга Ш.Оргил, нийгмийн бодлогийн хэлтсийн дарга Энхбат, Монголын сумо бөхийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Т.Жигжидсүрэн, удирдах зөвлөлийн гишүүн Д.Батсайхан нар оролцлоо. Тэмцээнийг өсвөр / 10, 11, 12, 13, 14 нас/ залуучууд 15-17 насны ангиллаар явагдаж нийт 75 тамирчид нас тус бүрийн ангилалд өрсөлдөж жин жингийн аваргууд тодорлоо. Аварга болсон тамирчдыг Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийг олгож Аймгийн засаг дарга тэдэнд урам зориг, авьяас чадварыг үнэлэн зөвхөн амжилт авчираарай гээд Улсын аваргад оролцох зардлыг бүрэн хариуцах болсон.



Хөдөлгөөн эрүүл мэнд нийтийн биеийн тамирын арга хэмжээг өргөжүүлэхэд ажил төрөлгүй байгаа иргэдийг татан оролцуулах чиглэлээр Сүхбаатар сумын МАН-ын 8 үүрийн дунд Дуун цэнгүүнийг найрал дуу, хослол дуу, бүжиг гэсэн 3



төрлөөр зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Тус арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд аймгийн МАН-ын дарга Ш.Оргил оролцож 8 үүрийн авъяаслаг гишүүдээ дэмжиж 1600000 төгрөгний урамшуулал олголоо. Нийлбэр дүнгээр Ариунтуяа даргатай 4-р үүр тэргүүлээ.

Дэлхийн биет бус өвд бүртгэгдсэн, Үндэсний спортын нэгэн төрөл шагайн харвааны өв соёлыг хойч үе хүүхэд залуучууддаа түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээж хөгжүүлэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах шагайн харваан тэмцээнийг аймгийн ЗДТГ, аймгийн Шагайн харвааны холбоо, аймгийн ерөнхий боловсролын бүрэн дунд спортын сургууль хамтран зохион байгуулсан. Энэ удаагийн аймгийн аваргад 17 сумын 28 багийн 300 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Аймгийн Засаг дарга Ш.Оргил



үндэсний өв соёлоо хөгжүүлж түгээн дэлгэрүүлэхэд бодит дэмжлэгийг үзүүлнэ гэдгээ илэрхийлж Шаамар сумын харваачдад шагайн өрөг зурхайг гардуулан өглөө. Цаашид бүх сумддаа энэ дэмжлэгийг үзүүлнэ гэдгээ хэллээ. Энэ үеэр тус спортыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж яваа спорт сургуулийн багийн харваач Монгол Улсын Гарамгай мэргэн Ж.Нямбаяр, Баруунхараа багийн харваач О.Гансүх, Сүхбаатар сумын харваач Э.Сод-Эрдэнэ нарыг аймгийн “Засаг даргын жуух бичиг”-ээр, “Аймгийн гоц мэргэн”-ий



болзол хангасан Баруунбүрэн сумын харваач Ж.Өлзийбаатар нарт шагналыг нь гардуулж өглөө.

Манай аймгийн харваачид Улсын аварга, Үндэсний их баяр наадам, Үндэсний спортын их наадмуудаас 13 түрүү авсан бахдам амжилтыг үзүүлээд байгаа. Харваачид ахас дээдсээ хүндлэх, ах дүүсийн барилдлагатай болох, нутаг усаа баясгах гээд олон сайхан чанаруудыг энэхүү спортоосоо суралцан үе дамжуулан сургасаар явна.Аймгийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Шагайн холбооны удирдлагыг хэлэлцэн шийдэж Сүхбаатар сумын Засаг дарга Т.Гантулга дахин сонгогдлоо

Буриад сурын харваан тэмцээнийг сурын холбооны санаачлагаар Хүдэр суманд аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг нээлттэй олон харваачдыг татан оролцуулах чиглэлээр нээлттэй явуулан тэмцээнд 80 гаруй харваачид оролцон Монгол улсын дархан мэргэн харваач 1, Монгол улсын мэргэн 1, спортын мастер 3, спортын дэд мастер 2 аймгийн цолтой 10 гаруй харваачид оролцсон тэмцээнийг өндөр чансаатай болгосон бол Халх сурын холбоо нь Дулаанхаан тосгонд үндэсний сурын хаврын харвааг зохион байгуулан 110 гаруй эрхий мэргэн харваачид оролцож цэц мэргэнээ уралдуулсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

Сүхбаатар сумын төвийн сургуулиудийн дунд хүүхдийг зам тээврийн хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийт, хүүхэд багачуудад зам тээврийн осол, хэргийн хор уршгийг таниулах, замын хөдөлгөөнд оролцох дадлыг зөв хэвшүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг сургуулийн өмнөх нас, ЕБСургуулийн 1-5 ангиудын дунд хамтран зохион байгууллаа.

Тус арга хэмжээний үед сургуулийн насны хүүхдүүдийг замын хөдөлгөөний дүрмийн зөв дадлыг эзэмшүүлэх чиглэлээр төвийн сургуулиуд хамрагдаж “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнд оролцсон хүүхэд бүрт гарын бэлэг гардуулав. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зөвлөлөөс 768 мянган төгрөгний санхүүжилтийг гарган хүүхэд бүрт гарын бэлгийг “Хүүхэд гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-аас гаргуулан ажилласан.

Ах дүү 4 спортын мастеруудын нэг ахмад тамирчин Чанцалын Туулын нэрэмжит ахмад волейболчдын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Сайхан суманд зохион байгуулсан. Тэмцээнийг Сайхан сумын ЗДТГазар, ЦШХКомпани, ахмад тамирчин Ч.Туулын гэр бүл, найз нөхөд нь ивээн тэтгэж явуулсан.Энэ удаагийн тэмцээнд эрэгтэй 9, эмэгтэй 8 багийн 137 тамирчин оролцож хурд хүч авьяас билгээ сорин өрсөлдөж эрэгтэй багуудаас Лхасүрэн ахлагчтай ЦШХКомпани баг тэргүүлсэн бол эмэгтэй багуудаас С.Одмаа ахлагчтай СББХКомпани баг

тэргүүлж багийн нийлбэр дүнгээр Орхон сумын баг тэргүүлэн шилжин явах цомын эзнээр тодорсон. Тус тэмцээний шилдэг тамирчнаар Сант сумын багийн Л.Отгонжаргал, Орхон сумын багийн тамирчин Ж.Золзаяа нар шалгарч тусгай шагналаар шагнагдсан.

Аймгийн засаг даргын нэрэмжит цомын төлөөх тэмцээнийг нийтийн биеийн тамир болон спортын 8 төрлөөр / нийт 56 байгууллагыг хамруулан үйл ажиллагааны чиглэлээр 20 баг болгон бүх төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулсан арга хэмжээг Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 1240 гаруй / эмэгтэй 580/ тамирчин төлөөлөгчид оролцуулан биеийн тамир спортод төрийн манлайлалыг харуулан үзэл суртал, зохион байгуулалтын өндөр хэмжээнд бусдад үлгэр дууриал үзүүлсэн арга хэмжээ боллоо.Тэмцээний үйл ажиллагаанд нийтийн биеийн тамирыг бүх байгууллагуудад жигд хөгжүүлэх чиглэлээр ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тусган оролцуулнаар байгууллага бүр ажлын байрны дасгалыг хийж суран цаашид байнга тэмцээнд оролцуулж байхаар болсон нь хүн бүрийн хэвшил болох чиглэлийг тавьж өглөө.



Тэмцээний нэгдсэн дүнгээр зохион байгуулалт спортын ур чадвараа гарган ЭМГазар тэргүүлэн удаах байранд Гаалийн газар, Шүүх прокурорын байгууллага шалгарсан байна.Тэмцээний гол онцлого нь үйл ажиллагааг нийтийн биеийн тамир луу чиглүүлсэн арга хэмжээг оруулж / ажлын байрны дасгал, усан сэлэлт,/ өгч шинэлэг хэлбэрээр төрийн байгууллагуудыг хамруулж чадсан .

Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат хурц арслан Г,Жаргалтулгын нэрэмжит үндэсний бөхийн 8 дахь удаагийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Мандал сумын Хэрх тосгоны Соёлын төвд зохион байгууллаа.Тэмцээний гол ач холбогдол нь Монгол үндэсний бөхийн ёс жаяг, зан заншил, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх ахмад тамирчдын залгамж халааг бэлтгэн гаргах, ахмад тамирчдаа дээдлэн хүндэтгэхэд чиглэгдэнэ.Тэмцээнд Сүхбаатар, Мандал, Дулаанхан, Сайхан, Шаамар, Хэрх, Орхонтуул, Цагааннуур, Зүүнбүрэн, Түшиг, Сант зэрэг сумдын 11 байгууллагын 80 гаруй тамирчид ахлах дунд бага гэсэн гурван ангиллаар оролцож уран мэхээ уралдуулан барилдаж байгийн дүнгээр тэргүүн байранд Э.Сүхбаатар дасгалжуулагчтай Мандал спортын цогцолбор, удаах байранд Н.Бүрэнцогт дасгалжуулагчтай Орхонтуул, Д,Оюунтөмөр дасгалжуулагчтай Биеийн тамир спортын газрын баг тамирчид шалгарсан байна. Тус тэмцээнд Г,Жаргалтулга агсаны гэр бүл үр хүүхдүүдээс нь уламжлал болгон уран гараа дэвээтэй, ирээдүйн аварга, дайчин барилдаантай, уран барилдаантай, өсөх ирээдүйтэй бөхчүүдийг шалгаруулан шагнаж урамшууллаа.



Тулгар төрийн 2228 жил, Их монгол улсын 813 жил, Ардын хувьсгалын 98 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 88 жилийн түүхт их ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу эрийн гурван наадам, шагайн харваа, шатар, гудамжны сагсан бөмбөг зэрэг төрлүүдээр



арга хэмжээг өргөжүүлэн зохион байгууллаа. Үндэсний бөхийн барилдаанд 128 бөхчүүд бяр чадал, уран мэхээ уралдуулан барилдаж Аймгийн арслан Б.Орхонбаяр түрүүлж Аймгийн хурц арслан цол хүртсэн бол үндэсний сурын тэмцээнд нийт 112 харваачид оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдөж, зохион байгуулсан шатрын тэмцээнд нийт 56 шатарчин гудамжны сагсан бөмбөгийн тэмцээнд 16 баг оролцож 80 гаруй тамирчдыг оролцуулан баяр наадмын үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллаа.

Улсын их хурлын гишүүн Н.Оюундарийн нэрэмжит “Иргэдийн спортын наадам” –ыг 2 дахь жилдээ “Айл өрх бүрт биеийн тамир спортыг хүргэх” уриан дор 5 сум, 1 тосгоны / Хүдэр, Алтанбулаг, Жавхлант, Шаамар, Сүхбаатар/ дунд спорт, биеийн тамирын 5 төрлөөр / сагсан бөмбөг, волейбол, олс таталт, гэр бүлийн



тэмцээн, ажлын байрны дасгал / явагдаж нийлбэр дүнгээр Сүхбаатар сумын 2-р баг тэргүүлэн 2 дахь жилдээ аваргаар тодорсон. Энэ жилийн арга хэмжээнд ажлын байрны дасгалыг оруулж өгсөнөөр нийтийн биеийн тамирт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэн оролцогчдын тоо 700 хүрч нэмэгдсэн нь онцлог байлаа.

Нийтийн биеийн тамир спортыг өргөжүүлэх чиглэлээр Аймгийн хэмжээнд Дугуйтай өдөрлөг зохион байгуулахаар гаргасан удирдамжийн дагуу Сүхбаатар, Мандал, Сайхан суманд өдөрлөг, аялалыг зохион байгуулан 240 гаруй дугуйтай иргэдийг хамруулж 1 өдрийн эмгүй үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.

Аймгийн засаг даргын 2016- 2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2,3,11 дэх заалтыг сум орон нутагт хэрэгжүүлэх үйлд ажиллагааг нь идэвхжүүлэх чиглэлээр сумдад ажлын чиглэлийн хуваарь гарган тамгын газрын даргаар батлуулан эхний ээлжинд Баянгол, Мандал, Хэрх, Түнхэл тосгоны засаг дарга, тосгоны захирагч спорт цогцолборын ажилчидтай ажил төрлийн шугмаар уулзан сум байгууллагын хэмжээнд ажлын байрны дасгал болон өглөөний гимнастикийг байнга хийж хэвшүүлэх талаар зааварчилгаа өгч ажиллаа. Ажиллах хугацаанд Хэрх тосгоны төрийн байгууллагууд сургууль, Спорт цогцолборын өмнөх талбайд ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хийгдэж байгаа гимнастик нь тогтмолжиж хийж хэвшсэн байгаа нь шинэлэг бөгөөд улам өргөжүүлэх талаар зөвлөгөө өгсөн.

Аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр Аймгийн ЗДТГазар, Хүнс хөдөө аж



ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Монголын тогооч нарын нэгдсэн холбоо хамтран Хангайн бүсийн аймгуудын тогооч нарын ажил мэргэжил, урлаг, спортын наадмыг аймаг орон нутагтаа хүлээн авч зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 9 аймгийн 110 гаруй мэргэжлийн тогооч нар оролцож спортын арга хэмжээ / волейбол/ ажил мэргэжлийн уралдааныг спортын ордонд

явуулсан.

Аймгийн хэмжээний ахмадуудын хөдөлгөөний идэвх санаачлагыг өрнүүлэн,



Атрын 60 жилийн ойн хүрээнд ахмадууд дуулж байна цэнгээнт бүжгийн арга хэмжээг зохион байгуулан явуулсан. Арга хэмжээнд 17 сумын ахмадууд хуран цугларч дуу бүжгийн тэмцээнүүдэд маш их идэвх санаачлагатай



оролцсон,

Аймгийн засаг даргын нэрэмжит 17 сумын ИТХурал, Засаг даргын тамгын газар зэрэг төрийн албан хаагчдын цомын төлөөх нөхөрсөг уулзалт тэмцээнийг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Тэмцээний үйл ажиллагаанд нийтийн биеийн тамирыг бүх байгууллагуудад жигд хөгжүүлэх чиглэлээр ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тусган оролцуулнаар сум бүр ажлын байрны дасгалыг хийж суран цаашид байнга тэмцээнд оролцуулж байхаар болсон нь хүн бүрийн хэвшил болох чиглэлийг тавьж өглөө. Энэ удаагийн тэмцээнд спортын 7 төрөлд 17 сумын 374 тамирчид хурд хүч, авхаалж самбаа, ур чадвараа гарган өрсөлдөж багийн дүнгээр тэргүүн байранд 45 оноогоор Мандал сум, дэд байранд 64 оноогоор Сайхан сум, гутгаар байранд 66 оноогоор Сүхбаатар сумын ЗДТГазрын баг тамирчид шалгарсан.

“Хөгжилд тэмүүлсэн-Сүхбаатарчууд” ТББ-аас зохион байгуулсан сагсан бөмбөгийн нээлттэй тэмцээнд Сэлэнгэ, Дархан-Уул, Баянхонгор аймаг,

Улаанбаатар хотоос хүрэлцэн ирсэн эрэгтэй 23, эмэгтэй 8 баг оролцож хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Эрэгтэй

1-р байранд Дархан-Уул аймаг “Дархан +30” баг

2-р байранд Сэлэнгэ аймаг “Найзууд лиг” баг

3-р байранд Сэлэнгэ аймаг “U17” баг

Эмэгтэй

1-р байранд Баянхонгор аймаг “Мазаалай” баг

2-р байранд Сэлэнгэ аймаг “Баруунхараа” баг

3-р байранд Сэлэнгэ аймаг “Сэлэнгэ” баг тамирчид тус тус шалгарлаа.

“Монголын ротари клубүүдийн спортын их наадам”-ыг анх удаа орон нутагт Сэлэнгэ ротари клуб хариуцан хамтран зохион байгууллаа. Тус наадамд олон улсын ротарийн 3450 дүүргийн үе үеийн бүсийн захирагч нар, одоогийн 9, 10-р бүсийн захирагчид, анх итгэмжлэн батлан дааж “ээж” клубээр ажилласан “Хүрээ” ротари клуб, мөн зорилго нэгтэй ажилладаг “Улаанбаатар”, “Номт”, “Ulaanbaatar peace avenue”, “Нарлаг Улаанбаатар”, “Улаанбаатар Хангарьд”, “Нийслэл”, “Ulaanbaatar central” зэрэг клубүүдийн 100 гаруй тамирчид спортын 5 төрөлд өрсөлдлөө.

Тэмцээний нийлбэр дүнгээр “Улаанбаатар Хангарьд” RC Тэргүүн байр эзэлж Шилжин явах цомын эзэн болж ирэх жилийн спортын наадмыг зохион байгуулах үүргийг гардан авлаа. Дэд байрыг “Ulaanbaatar peace avenue” RC, Гуравдугаар байрыг “Сэлэнгэ” RC тус тус эзэллээ.



Аймаг орон нутагтаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудыг спортод дур сонирхолтой болгох чөлөөт цагаа зөв өнгөрөөх хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн спортын 5 төрлөөр /волейбол, шатар, даам, бинго, теннис/ Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хамтран зохион байгуулж тэмцээнд Сүхбаатар, Мандал, Баянгол, Жавхлант, Ерөө, Цагааннуур, Сайхан, Алтанбулаг сумын 8 багийн 110 тамирчин оролцож багийн дүнгээр тэргүүн байранд Сүхбаатар сумын баг тамирчид тэргүүлсэн байна.

Улаанбаатар төмөр замын татах хэсгийн хойт бүсийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах уламжлалт тэмцээнийг орон нутагтаа Сүхбаатар депо, Замчин клуб, Сүхбаатар татах хэсэгтэй хамтран зохион байгуулж тэмцээнийг залуучууд, ахмад гэсэн 2 ангиллаар явуулан Улаанбаатар, Дархан, Орхон, Сэлэнгийн аймгийн клуб, холбоодын нийт 15 багийн 135 тамирчид өрсөлдөж залуучуудын тэмцээнд Улаанбаатар хотын Зүтгүүр баг тэргүүлсэн бол ахмадын ангилалд Сэлэнгэ аймгийн Депогийн баг тэргүүлж байгууллагынхаа ажилчдынхаа эрүүл мэндэд анхааран, хөдөлгөөний хомсдолоос гаргаж, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүллээ.

Ахмад настаны эрүүл мэнд хөдөлгөөний хомсдол, дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд хийн дасгал, гангарааг бренд болгон аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр аймгийн Засаг дарга сум болон байгууллага, хорооны засаг дарга нарт үүрэг чиглэл болгон ажиллаж хийсэн ажлынхаа үр дүнг харахаар “Хөдөлгөөн урт наслалт” уриатай аймгийн Засаг даргын

ивээл дор аймгийн хэмжээнд хийн дасгал, гангараагаар тэргүүлж байгаа сум, мөн шагай няслах, шүүрэх, морь уралдуулах монгол наадгайн төрлүүдийг оролцуулсан Аймгийн хэмжээний арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 16 сум 2 тосгоны 360 гаруй ахмадууд хамрагдан хийн дасгал, гангараа, шагай няслах, шүүрэх, морь уралдуулах монгол наадгайн нийт 5 төрлөөр өрсөлдөж багийн нийлбэр дүнгээр 39 оноогоор Сүхбаатар сумын ахмадын хороо тэргүүлэн цом 1 сая төгрөгөөр, Сайхан сумын ахмадын хороо удаалан өргөмжлөл 800000 төгрөгөөр, гутгаар байранд Баруунбүрэн сумын ахмадын хороо шалгаран 600000 төгрөгөөр тус тус шагнагдсан. Энэ арга хэмжээг анх удаа ахмадын дунд зохион байгуулж байгаа бөгөөд уламжлалт болгон явуулж байхаар тогтсонд ахмадуудад ээлтэй нас биений онцлог хөдөлгөөнд тохирсон арга хэмжээ боллоо гэж оролцогсад дүгнэж байна.



Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн баярт зориулсан хүчит бөхийн барилдаанд Архангай аймгийн Булган сумын харьяат Зэвсэгт хүчний Алдар спортын хороо 150-р анги, Бөх билэгт дэвжээний бөх Улсын арслан Рэнцэнбямбын Пүрэвдагва, Ховд аймгийн Зэрэг сумын харьяат Зэвсэгт хүчний алдар спортын хорооны 034-р анги, “Торгоны зам” ХХК-ын бөх Улсын харцага Баярхүүгийн Бат-Өлзий, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын харьяат Зэвсэгт хүчний алдар спортын хорооны 337-р анги, Таван хан дэвжээний бөх Улсын харцага Бат-Очирын Одгэрэл, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын харьяат “Хос түрүү” ХХК, “Таван хан” дэвжээний бөх Улсын начин Батсайханы Орхонбаяр, Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат ОБЕГ-ын “Аврагч” спортын хороо, “Мон Зол” ХХК, “Таван хан” дэвжээний бөх Улсын начин Насанцогтын Баярбаатар нарын тэргүүтэй Улс, Аймаг, Сумын цолтой болон залуу бөхчүүд оролцсон 64 бөх барилдаж Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын харьяат “Хос түрүү” ХХК, “Таван хан” дэвжээний бөх Улсын начин Батсайханы Орхонбаяр түрүүлэн цугларсан олон наадамчин түмнээ баягасан.

Сэлэнгэ аймгаас төрөн гарсан аймаг сумынхаа нэрийг өндөрт өргөн яваа энэ жилийн 2 шинэ начин болох Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын харьяат “Хос түрүү” ХХК, “Таван хан” дэвжээний бөх Улсын начин Батсайханы Орхонбаяр, Сэлэнгэ



аймгийн Мандал сумын харьяат ОБЕГ-ын “Аврагч” спортын хороо, “Мон Зол”ХХК, “Таван хан” дэвжээний бөх Улсын начин Насанцогтын Баярбаатар нарт Сэлэнгэ аймгийн засаг дарга Шархүүгийн Оргил болон Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдын дарга Гаршаавын Бямбаа нар хүндэтгэл үзүүллээ.